

/2019.08.22-ний өдрийн байдлаар /

Үндэсний үйлдвэрлэгч “Түмэн шувуут” ХКомпани нь үйл ажиллагаагаа өргөтгөн Хөдөө аж ахуйн цогц төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс IPO гаргаж нийт 10 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараахи үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн. Үүнд:

Өндөглөгч тахианы аж ахуйг өргөтгөх	2,8 тэрбум
Шинээр шувууны аж ахуй байгуулах	3,9 тэрбум
Сангасны бордооны үйлдвэр барих	1,7 тэрбум
Усалгаатай газар тариаланг өргөжүүлэх	1,6 тэрбум

Хөдөө аж ахуйн цогц шийдэл төсөл хөтөлбөрийн бүтээн байгуулалтын ажил төлөвлөгөөний дагуу эхэлж, тэдгээрт зориулсан хөрөнгө дараахи байдлаар зарцуулагдаж байна.

**Өндөглөгч тахианы аж ахуйг өргөтгөх:**

“Түмэн шувуут” ХК-ний үндсэн үйл ажиллагаа нь өндөглөгч тахианы аж ахуй бөгөөд тус аж ахуйг өргөтгөх зорилгоор Өндөглөгчийн 8-р байр болон Өндөг боловсруулах үйлдвэрийг шинээр барих юм.

Эдгээр барилгын гүйцэтгэгчээр “Бээвэр” ХХКомпани ажиллаж байгаа ба барилга барих гэрээ байгуулсаны урьдчилгаанд **105,502,320** төгрөг шилжүүлсэн.

Мөн БНХАУ-ын “GGP Equipment CO” компанитай худалдах, худалдан авах гэрээ байгуулан нийт **495,356,745** /1,280.300 юань/ төгрөгийн Өндөглөгчийн 8-р байрны тоног төхөөрөмж худалдан авсан. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралтын ажил 90 хувьтай явж байна.

Өндөглөгчийн 8-р байрны барилгын сэндвичэн материалыг “Монголиан Дуовэй трейдинг” ХХКомпаниас худалдан авахад **449,187,156** /1,162,827 юань/ төгрөг, барилгын материалын бусад зардалд **188,471,124** төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Шинээр барих өндөг боловсруулах үйлдвэрийн барилгын гүйцэтгэлийн урьдчилгаанд **53,460,000** төгрөг, барилгын сэндвичэн материалын зардал худалдан авахад **226,959,489** /578,514 юань/төгрөгийг “Монголиан Дуовэй трейдинг” ХХКомпанид, барилгын суурийн материалд нийт **309,717,726** төгрөгийг зарцуулсан.

**Шинээр шувууны аж ахуй байгуулах:**

Шинээр байгуулах 200,000 шувуутай тахианы аж ахуйг Сонгинохайрхан дүүргийн 21 хороо, Их булаг хэмээх газар барихаар төлөвлөж, 20 га газрыг **215,997,536** төгрөгөөр худалдан авсан. Одоо тус газарт цахилгаан эрчим хүч, усны хангамжийн асуудлуудыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад хандаад байна.

Шинээр байгуулах шувууны аж ахуйд эхний ээлжинд Өндөглөгчийн 1 байр, Дэгдээхэйн 1 байр тус тус барих ба эдгээр барилгын гүйцэтгэгчээр “Дуут зам” ХХК, “Ган-Эрдэнэ” ХХКомпаниуд ажиллаж байна. Барилгын ажлын гэрээний урьдчилгаанд **48,000,000** төгрөг шилжүүлсэн.

Тус аж ахуйд шинээр барих Өндөглөгчийн 1-р байр, Дэгдээхэйн 1-р байрнуудын тоног төхөөрөмжийг БНХАУ-ын “GGP Equipment CO” компаниас авах тул тоног төхөөрөмжийн

урьдчилгаанд **289,096,920** төгрөг, эдгээр барилгын сэндвичэн материалын урьдчилгаанд **290,000,000** төгрөгийг “Монголиан Дуовэй трейдинг” ХХК компаниудад тус тус шилжүүлсэн.

**Сангасны бордооны үйлдвэр барих:**

ХУД-ийн 13-р хороонд байрлах шувууны аж ахуйн дэргэд органик бордоо үйлдвэрлэх сангасны бордооны үйлдвэр шинээр байгуулах юм. Бордооны үйлдвэрийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Дуут зам” ХХК ажиллаж байгаа ба гэрээний урьдчилгаанд **136,400,000** төгрөг зарцуулсан.

Японы Kohshin Engineering Co.,Ltd компаниас нийт **827,444,682** /311,097 ам.доллар/ төгрөгийн Бордооны үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авахаар гэрээ байгуулсан бөгөөд 09 сарын эхээр хүлээн авах юм.

Бордооны үйлдвэрийн карказ төмрийн үнэ болох **111,099,000** /290,000 юань/ төгрөгийг Song Hong Liang компанид төлж, үйлдвэрийн барилгын материалын бусад зардалд **50,104,630** төгрөгийг зарцуулсан.

Одоогийн байдлаар бордооны үйлдвэрийн барилгын ажил сурийн ажлыг эхлүүлээд байна.

**Усалгаатай газар тариаланг өргөжүүлэх:**

“Түмэн шувуут” ХКомпани нь зөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулахаас гадна хөдөө орон нутаг тэр тусмаа алс холын Увс аймгийн Баруунтуруун суманд байрлах “Усжуулах” ХК-ний 4000 га газарт хиймэл нуурын усжуулалтын системд хөрөнгө оруулалт хийн сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Энэхүү бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 05 сараас 06 сарын хооронд 700 гаруй га газрыг орчин үеийн усалгааны тоног төхөөрөмжөөр тоноглон бүрэн ашиглалтад оруулж, энэ жилийн тухайд 473 га-д улаанбуудай тариалж байна. Нийт **889,202,474** төгрөгийн үнэ бүхий усалгааны тоног төхөөрөмж суурилуулсан.

“Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компани нь андеррайтейр байгууллагаар хамтран ажилласан “Голомт Капитал” ҮЦКомпанид үнэт цаасны брокерийн үйлчилгээний хөлсөнд **567,424,000** төгрөг, Монголын хөрөнгийн биржид үнэт цаас бүртгүүлэхэд **40,000,000** төгрөг, эргэлтийн хөрөнгийн зардал буюу тэжээлийн түүхий эд болох эрдэнэ шиш, шар буурцаг ОХУ-аас импортлон авахад **1,155,972,038** төгрөгийг тус тус зарцуулаад байна.

Ийнхүү бүтээн байгуулалтын ажлын хөрөнгийн зарцуулалт зориулалтын дагуу явагдаж байна.